

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

| | | |
|-------|---|----|
| 1 | Аудитын гэрчилгээ | 2 |
| 2 | Аудитын тайлан | 4 |
| 2.1 | Оршил..... | 4 |
| 2.2 | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 4 |
| 2.3 | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 5 |
| 2.4 | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 5 |
| 2.5 | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 6 |
| 2.6 | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 7 |
| 2.7 | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 7 |
| 2.8 | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... | 8 |
| 2.8.1 | Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал..... | 8 |
| 2.9 | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 9 |
| 2.10 | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга | 9 |
| 2.11. | Шилэн дансны мэдээлэл..... | 9 |
| 2.12 | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга..... | 9 |
| 2.13 | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... | 10 |
| 3 | Менежментийн захидал | 11 |
| 4 | Аудит хийсэн санхүүгийн тайлан | 13 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.СОВД ТАНАА

2019.02.25 № 06/260
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Совд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 30-наас 2019 оны 2 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын Ахлах аудитор Р.Цолмон хариуцаж хэрэгжүүлэв.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01/323 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь салбарын бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх замаар түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн орлого, бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн салбарын эдийн засгийн өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, аюулгүй, шим тэжээллэг хүнс, эрүүл ахуй, хэрэглээний шаардлага хангасан хувцас, хэрэгслээр хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэж, сайдад өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон шуурхай зөвлөгөө, мэдээ, мэдээлэл, дэмжлэг, салбарын төсөв, улсын болон орон нутгийн өмчийг үр ашигтай захиран зарцуулах, төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгахад оршино

гэж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мал аж ахуй, газар тариалан, хүнс, хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, хоршооны тогтвортой хөгжлийг хангах, эрчимжүүлэх, дотоод худалдаа болон маркетингийн бодлого, салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- Мал, амьтныг гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчний гаралтыг тогтвортой бууруулж, тархалтыг зогсоох, өвчингүй тайван бүсийг баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлэх;
- Хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хөрсний үржил шим, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн усан хангамжийг нэмэгдүүлэх, уст цэг, усалгааны тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, ашиглалт, эзэмшлийг сайжруулах, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах;
- Жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, хоршооны салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх, ажлын байрыг шинээр бий болгох, үнэ цэнийн сүлжээ, кластерийг хөгжүүлэх гэх мэт.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Малын генетик нөөцийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS” програм хангамж ашигладаг байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар материаллаг байдлын суурийг сонгон авав. Учир нийт орлого, нийт хөрөнгө эрсдэл багатай гэж үзэн нийт зардлаар материаллаг байдлын суурийг сонгон авав.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2018 оны нийт зардал 3,735,869.9 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 74,717.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь тус яамны дотоод хяналтын тогтолцоо сайн, эрсдэл бага гэж тооцсныг үндэслэв.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй

асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|-----|----------|---------|
| 1 | Зөвлөмж өгсөн | 2 | 54,202.0 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 0 | 0.0 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 0 | 0.0 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0.0 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0.0 | |
| | Дүн | 2 | 54,202.0 | |

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2018 оны үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2017 оны аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн жилийн

эцсийн үлдэгдэлээс 106,153.3 мянган төгрөгөөр зөрснийг аудитын явцад залруулав.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2012 оны А/100 дугаар тушаалаар албан хаагчдад зориулсан 48 айлын орон сууц, автомашины зогсоолыг барьж үнийн дүнгийн 40 хувь болох 1,068,327.3 мянган төгрөгийг төрөөс дэмжлэг үзүүлж, 60 хувийг тус яамны албан хаагчид төлж барагдуулснаар тухайн байрныхаа өмчлөх үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг хувь хүмүүсийн нэр дээр гаргуулан авсан байна. Гэвч албан хаагчдын 1,068,327.3 мянган төгрөгийн 48 айлын орон сууц, авто машины зогсоолыг тус яамны санхүүгийн тайланд давхар бүртгэсэн байна.

Иймд дээрх асуудлыг холбогдох газарт хандан шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 3 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 3,355,895.3 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 3,349,873.3 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувийн хэрэгжилттэй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Үндсэн хөрөнгө

3.1.1 Илрүүлэлт:

Тус яамны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 44,555.6 мянган төгрөгийн ажилчдын орон сууц нь зориулалтын дагуу ашигладаггүй, тайлант онд тус барилгад хөрөнгийн дахин үнэлгээ хийгдээгүй байна. Энэ нь СС-ын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан Аргачлал батлах тухай тушаалыг зөрчсөн байна.

3.1.2 Өгсөн зөвлөмж:

СС-ын 2018 оны 207 дугаар тушаалыг баримтлан ажиллаж, холбогдох газарт хандан шийдвэрлүүлэх.

3.1.3 Эрсдэл:

Үнэн зөв байдал-Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

3.1.4 Төсвийн захирагчийн хариу:

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3.2 Зардал

3.2.1 Илрүүлэлт:

Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны Б-119 дүгээр тушаалаар Ерөнхий нягтлан бодогч /хуучнаар/ П.Энхбаярыг үүрэгт ажлаас нь чөлөөлснөөр Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2018 оны №101/ШШ2018-02393 дугаар захирамжийн дагуу ажилгүй байсан хугацааны цалин болох 9,646.4 мянган төгрөгийг төсвөөс олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д заасан "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ", Иргэний тухай хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

3.2.2 Өгсөн зөвлөмж:

Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, Иргэний тухай хуулийн 498 дугаар хуулийн 498.5-ыг тус тус баримтлан ажиллаж, 9,646.4 мянган төгрөгийг авлага дансанд бүртгэж, холбогдох этгээдээр төлүүлэх.

3.2.3 Эрсдэл

Үнэн зөв байдал-Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

Эрх ба үүрэг - Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, уг аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, төлөх үүрэгтэй байх.

3.2.4 Төсвийн захирагчийн хариу:

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 176,765,028.36 | 153,130,163.36 |
| 33 | АВЛАГА | 9,383,070.00 | - |
| 335 | Бусад авлага | 9,383,070.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 9,383,070.00 | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 167,381,958.36 | 153,130,163.36 |
| 354 | Хангамжийн материал | 167,381,958.36 | 153,130,163.36 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,952,430.00 | 1,676,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 130,830,450.00 | 130,830,450.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 18,820.00 | 1,119,911.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 4,794,191.00 | |
| 35470 | Бусад хангамжийн материал | 29,786,067.36 | 19,503,002.36 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 5,905,760,949.89 | 8,001,525,614.29 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 5,905,760,949.89 | 8,001,525,614.29 |
| 392 | Биет хөрөнгө | 5,898,030,772.96 | 7,732,866,457.36 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 6,014,911,263.88 | 8,099,372,284.49 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (797,114,869.42) | (858,133,782.99) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 465,925,242.78 | 309,925,242.78 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (454,208,413.00) | (309,925,242.78) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,537,068,037.09 | 1,366,021,671.16 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,136,394,952.44) | (1,091,927,114.84) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 928,117,194.83 | 825,364,970.58 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (688,117,830.76) | (620,331,571.26) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 27,845,100.00 | |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | | 20,000,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | | (7,499,999.78) |
| 393 | Биет бус хөрөнгө | 7,730,176.93 | 268,659,156.93 |
| 39301 | Програм хангамж | 1,950,000.00 | 112,060,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,950,000.00) | (91,660,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 23,100,000.00 | 268,248,980.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (15,369,823.07) | (19,989,823.07) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 6,082,525,978.25 | 8,154,655,777.65 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 6,082,525,978.25 | 8,154,655,777.65 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 6,082,525,978.25 | 8,154,655,777.65 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 6,263,125,490.95 | 6,518,504,470.95 |
| 51101 | Өмч: - төрийн | 6,263,125,490.95 | 6,518,504,470.95 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (180,599,512.70) | (314,662,934.19) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (180,599,512.70) | (180,599,512.70) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (134,063,421.49) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 1,950,814,240.89 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 6,082,525,978.25 | 8,154,655,777.65 |

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 5,152,478,652.13 | 3,797,648,764.79 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 57,468,892.92 | 203,200,679.19 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 40,028,573.14 | 203,200,679.19 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 40,028,573.14 | 203,200,679.19 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 25,577,181.14 | 10,680,270.30 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,397,070.00 | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 6,054,322.00 | 192,520,408.89 |
| 122 | Тусламжийн орлого | 17,440,319.78 | - |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | 17,440,319.78 | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 5,095,009,759.21 | 3,594,448,085.60 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 4,294,165,100.00 | 3,343,428,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,294,165,100.00 | 3,343,428,100.00 |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 800,844,659.21 | 245,018,597.00 |
| 133003 | Хөрөнгийн | 25,449,999.21 | |
| 133004 | Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт | 775,394,660.00 | |
| 133005 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | | 245,018,597.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | - | 6,001,388.60 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | | 6,001,388.60 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 5,621,172,659.59 | 3,735,869,918.39 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,621,172,659.59 | 3,735,869,918.39 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,758,037,115.84 | 2,996,068,769.40 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,423,833,471.05 | 1,320,184,721.31 |
| 210101 | Үндсэн цалин | 1,164,899,128.60 | 893,666,721.31 |
| 210102 | Нэмэгдэл | | 258,078,700.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 134,001,025.32 | 168,439,300.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 124,933,317.13 | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 158,354,000.00 | 158,306,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 103,444,666.11 | 106,404,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,116,255.44 | 12,975,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 13,708,052.96 | 10,380,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,726,440.94 | 2,595,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,358,584.55 | 25,950,700.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 155,140,600.00 | 233,195,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 70,743,300.00 | 94,932,300.00 |
| 210302 | Түлш, халаалт | 71,211,700.00 | 105,397,300.00 |

| | | | |
|-------------|--|--------------------------------|--------------------------------|
| 210303 | Цэвэр, бохир ус | 13,185,600.00 | 32,866,200.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 168,888,190.10 | 75,965,663.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 110,892,800.00 | 23,459,119.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 35,957,831.00 | 25,953,184.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 21,103,411.10 | 26,553,360.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 934,148.00 | |
| 2105 | Нормативт зардал | 246,999.00 | 300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 246,999.00 | 300.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,516,920.40 | 15,884,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 535,320.00 | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 200,000.00 | 18,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,781,600.40 | 15,866,100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 22,732,815.00 | 34,093,625.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 22,732,815.00 | 34,093,625.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,360,395,921.99 | 395,585,229.33 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,351,574,415.31 | 386,962,529.33 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 5,010,906.68 | 4,895,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,626,480.00 | 1,698,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 570,220.00 | 157,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,613,900.00 | 1,871,200.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,459,928,198.30 | 762,852,430.76 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 614,317,548.86 | 405,213,820.27 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 845,610,649.44 | 357,638,610.49 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 863,135,543.75 | 739,801,148.99 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 277,408,525.67 | 349,195,514.56 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 277,408,525.67 | 349,195,514.56 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 567,592,069.00 | 385,384,619.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 24,132,780.00 | 27,692,060.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 383,476,056.00 | 258,235,259.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 80,336,333.00 | 99,457,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 79,646,900.00 | |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 18,134,949.08 | 5,221,015.43 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 18,134,949.08 | 5,221,015.43 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>(468,694,007.46)</u> | <u>61,778,846.40</u> |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 90,353,811.10 | 195,842,267.89 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 90,353,811.10 | 167,172,204.50 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | | 28,670,063.39 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (90,353,811.10) | (195,842,267.89) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>(559,047,818.56)</u> | <u>(134,063,421.49)</u> |

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|--------------------------------|--------------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>4,327,153,351.14</u> | <u>3,355,094,370.30</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 32,988,251.14 | 11,666,270.30 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 32,988,251.14 | 11,666,270.30 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 32,988,251.14 | 11,666,270.30 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 24,591,181.14 | 11,666,270.30 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,397,070.00 | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,294,165,100.00 | 3,343,428,100.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 4,294,165,100.00 | 3,343,428,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,294,165,100.00 | 3,343,428,100.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>4,326,793,788.14</u> | <u>3,348,881,270.30</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,326,793,788.14 | 3,348,881,270.30 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,560,870,010.39 | 2,598,311,581.31 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,388,618,200.00 | 1,320,184,721.31 |
| 210101 | Үндсэн цалин | 1,088,678,000.00 | 893,666,721.31 |
| 210102 | Нэмэгдэл | | 258,078,700.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 134,861,800.00 | 168,439,300.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 165,078,400.00 | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 158,354,000.00 | 158,306,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 102,448,100.00 | 106,404,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,063,800.00 | 12,975,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,157,700.00 | 10,380,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,789,700.00 | 2,595,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,894,700.00 | 25,950,700.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 155,140,600.00 | 233,195,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 70,743,300.00 | 94,932,300.00 |
| 210302 | Түлш, халаалт | 71,211,700.00 | 105,397,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 13,185,600.00 | 32,866,200.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 51,476,900.00 | 70,357,360.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 14,550,300.00 | 20,950,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,320,300.00 | 20,840,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 19,662,900.00 | 27,623,360.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 943,400.00 | 943,400.00 |
| 2105 | Нормативт зардал | 264,700.00 | 269,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 264,700.00 | 269,300.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,063,640.00 | 18,980,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,235,300.00 | 1,645,600.00 |

| | | | |
|-------------|--|----------------------------|------------------------------|
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 461,540.00 | 468,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,366,800.00 | 16,866,800.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 23,078,500.00 | 35,372,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 23,078,500.00 | 35,372,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,381,589,689.87 | 387,001,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,372,768,183.19 | 378,378,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 5,010,906.68 | 4,895,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,626,480.00 | 1,698,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 570,220.00 | 157,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,613,900.00 | 1,871,200.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 394,283,780.52 | 374,643,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 394,283,780.52 | 374,643,600.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 765,923,777.75 | 750,569,688.99 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 277,408,525.67 | 349,195,514.56 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 277,408,525.67 | 349,195,514.56 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 461,983,233.00 | 396,153,159.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 25,000,000.00 | 32,315,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 277,000,000.00 | 264,380,259.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 80,336,333.00 | 99,457,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 79,646,900.00 | |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 5,221,015.43 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 5,221,015.43 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 26,532,019.08 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 26,532,019.08 | |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>359,563.00</u> | <u>6,213,100.00</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | <u>359,800.00</u> | <u>6,213,100.00</u> |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | <u>359,800.00</u> | <u>6,213,100.00</u> |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | <u>359,800.00</u> | <u>6,213,100.00</u> |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 359,800.00 | 6,213,100.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>(359,800.00)</u> | <u>(6,213,100.00)</u> |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | <u>0.00</u> | <u>0.00</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | -237.00 | 0.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 237.00 | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-------------------------|------------------------|-------------|---|
| C01 | 2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 6,263,125,490.95 | | -180,599,512.70 | | 6,082,525,978.25 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 6,263,125,490.95 | 0.00 | -180,599,512.70 | 0.00 | 6,082,525,978.25 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | 0.00 |
| C08 | 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 6,263,125,490.95 | 0.00 | -180,599,512.70 | 0.00 | 6,082,525,978.25 |
| D01 | 2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 6,263,125,490.95 | 0.00 | -180,599,512.70 | 0.00 | 6,082,525,978.25 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 6,263,125,490.95 | 0.00 | -180,599,512.70 | 0.00 | 6,082,525,978.25 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | 1,950,814,240.89 | | | 1,950,814,240.89 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 255,378,980.00 | | | | 255,378,980.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | -134,063,421.49 | | -134,063,421.49 |
| D09 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 6,518,504,470.95 | 1,950,814,240.89 | -314,662,934.19 | 0.00 | 8,154,655,777.65 |

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү |
|-----------------------|--|-----------------------|------------------|-------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,355,895,300.00 | 3,349,873,354.87 | 99.8 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,355,895,300.00 | 3,349,873,354.87 | 99.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,606,525,100.00 | 2,604,524,681.31 | 99.9 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,320,254,600.00 | 1,320,184,721.31 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 893,736,600.00 | 893,666,721.31 | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 258,078,700.00 | 258,078,700.00 | 100.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 168,439,300.00 | 168,439,300.00 | 100.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 158,306,200.00 | 158,306,200.00 | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 106,404,800.00 | 106,404,800.00 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,975,400.00 | 12,975,400.00 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,380,300.00 | 10,380,300.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,595,000.00 | 2,595,000.00 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,950,700.00 | 25,950,700.00 | 100.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 233,195,800.00 | 233,195,800.00 | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 94,932,300.00 | 94,932,300.00 | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 105,397,300.00 | 105,397,300.00 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 32,866,200.00 | 32,866,200.00 | 100.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 70,396,900.00 | 70,357,360.00 | 99.9 |
| 210401 | Бичиг хэрэг | 20,950,300.00 | 20,950,300.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,840,300.00 | 20,840,300.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 27,662,900.00 | 27,623,360.00 | 99.9 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 943,400.00 | 943,400.00 | 100.0 |
| 2105 | Нормативт зардал | 269,300.00 | 269,300.00 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 269,300.00 | 269,300.00 | 100.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 25,194,000.00 | 24,725,500.00 | 98.1 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,858,700.00 | 7,858,700.00 | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 468,500.00 | | 0.0 |
| 210604 | Урсгал засвар | 16,866,800.00 | 16,866,800.00 | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 35,373,500.00 | 35,372,500.00 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 35,373,500.00 | 35,372,500.00 | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 388,891,200.00 | 387,469,700.00 | 99.6 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 380,268,500.00 | 378,847,000.00 | 99.6 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 4,895,100.00 | 4,895,100.00 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,698,900.00 | 1,698,900.00 | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 157,500.00 | 157,500.00 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 1,871,200.00 | 1,871,200.00 | 100.0 |

| | | | | |
|---------------|---|------------------|------------------|-------|
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 374,643,600.00 | 374,643,600.00 | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 374,643,600.00 | 374,643,600.00 | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 749,370,200.00 | 745,348,673.56 | 99.5 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 349,197,300.00 | 349,195,514.56 | 100.0 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 349,197,300.00 | 349,195,514.56 | 100.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 400,172,900.00 | 396,153,159.00 | 99.0 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 34,304,800.00 | 32,315,600.00 | 94.2 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 264,400,000.00 | 264,380,259.00 | 100.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 101,468,100.00 | 99,457,300.00 | 98.0 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 3,364,362,500.00 | 3,355,094,370.30 | 99.7 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 3,355,895,300.00 | 3,343,428,100.00 | 99.6 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,355,895,300.00 | 3,343,428,100.00 | 99.6 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 8,467,200.00 | 11,666,270.30 | 137.8 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,467,200.00 | 11,666,270.30 | 137.8 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 108 | 108 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 14 | 14 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 94 | 94 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | | | |

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | | | |
|-------------------------------------|---|---------------------|------------------------------------|----------------------|----------------------------|
| Огноо: | 2018 он | Аудитын нэр: | Санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: | САГ-2019/90/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | | | Мянган төгрөг | |

| А | 1 | 3 | 4 | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|-----------------|----------------|--|-----------------|---------------------------------------|---|------------------------------------|
| | | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 3 | 4 | 5 | 9 | 10 |
| 1 | Үндсэн хөрөнгө | Тус яамны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 44,555.6 мянган төгрөгийн ажилчдын орон сууц нь зориулалтын дагуу ашигладаггүй, тайлант онд тус барилгад хөрөнгийн үнэлгээ хийгдээгүй байна. | 44,555.6 | Зөвлөмж өгсөн. | 1.Төрийн захиргааны удирдлагын газрын дарга 2.Ахлах нягтлан бодогч | 1.Т.Жамбалцэрэн 2.Б.Ариунжаргал |
| 2 | Зардал | ТНБД-ын 2016 оны Б-119 дүгээр тушаалаар Ерөнхий нягтлан бодогч /хуучнаар/ П.Энхбаярыг үүрэгт ажлаас нь чөлөөлснөөр Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2018 оны №101/ШШ2018-02393 дугаар захирамжийн дагуу ажилгүй байсан хугацааны цалин болох 9,646.4 мянган төгрөгийг төсвөөс олгосон байна. | 9,646.4 | Зөвлөмж өгсөн. | 1.Төрийн нарийн бичгийн дарга /хуучнаар/ | 1.Л.Баяртулга |
| Нийт дүн | | | 54,202.0 | | | |

